



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 01248

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 197 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,419,100.00 /дөрвөн сая дөрвөн зуун арван есөн мянга нэг зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 197 дугаар цэцэрлэг /Д.Хишигдулам/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 1,180,000.00 /нэг сая нэг зуун наян мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 4 нэр төрлийн 3,239,100.00 /гурван сая хоёр зуун гучин есөн мянга нэг зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 197 дугаар цэцэрлэг /Д.Хишигдулам/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ



115050000619



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын даргын 2020 оны 0.6-р сарын 08-ны өдрийн 01248-р тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 197 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУ-ын мөргөжлтийн дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	Хөргөгч	5	ш	1	1,731,300.00	1,731,300.00	1,731,300.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
2	Хөлдөөгч	5	ш	1	432,800.00	432,800.00	432,800.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
3	Хөгжим	5	ш	2	323,500.00	647,000.00	647,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
4	Угаалгын машин	5	ш	2	214,000.00	428,000.00	428,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
Тоног төхөөрөмжийн дүн				6		3,239,100.00	3,239,100.00	-				
5	Веб сайт	4	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-	Ашиглахаа больсон	Актлах	Устгах	Устгах
6	Нягтлангийн программ	4	ш	1	680,000.00	680,000.00	680,000.00	-	Шинэчлэгдсэн	Актлах	Устгах	Устгах
Биет бус хөрөнгийн дүн				2		1,180,000.00	1,180,000.00	-				
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				8	0	4,419,100.00	4,419,100.00	-				
Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө						3,239,100.00	3,239,100.00	-				
Актлах хөрөнгө						1,180,000.0	1,180,000.0	-				